



БАТЛАВ.  
МОНГОЛЫН ЭХ БАРИХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН  
ЭМЧ НАРЫН ХОЛБООНЫ ТЭРГҮҮН  
Д.ӨНӨРЖАРГАЛ

## МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ГОРИЛОГЧИД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Энэхүү тусгай шаардлагыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл зөвшөөрсөн өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай мөрдөнө.

### 1. АХЛАХ зэрэг горилогч эх барих эмэгтэйчүүдийн эмч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 1.1. Эрүүл мэндийн сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2019 оны А/513 дугаар тушаалаар батлагдсан 1 дүгээр хавсралтын 4.1.1-4.1.7 дох нийтлэг шаардлагыг хангасан байна.
- 1.2. Эх барих эмэгтэйчүүдийн практикт хийгддэг мэс засал, ажилбаруудын техникийг эзэмшсэн байна. Кесар мэс засал, умай өндгөвч дайврын хоргүй хавдар, умайн гадуурх жирэмсэн, умайгаас зангилаа авах зэрэг мэс заслуудын техникийг эзэмшсэн байна.  
(ажлын баталгаажсан тайлан)
- 1.3. Кесар мэс засал, умай өндгөвч дайврын хоргүй хавдар, умайн гадуурх жирэмсэн, умайгаас зангилаа авах мэс заслуудын аль нэгээр доорх шаардлагыг хангасан видео бичлэг хийсэн байна.
- 1.4. Хөдөө орон нутгаас ирж буй эмч нарыг ЭМС-513 ын 8.5 дагуу авна.
- 1.5. Мэс заслын видео хийх шаарлага ба нууцлал:
  - 1.5.1. 4к бичлэг дэмждэг сүүлийн үеийн гар утас, видео камер ашиглана.
  - 1.5.2. Өндөр нягтралтай (1080p-Full Definition/4k-UHD)
  - 1.5.3. Сүүдэр багатай, тод гэрэлтүүлэгтэй
  - 1.5.4. Гэрэлтүүлгийг зөв байрлалаас тусгана.
  - 1.5.5. Халдвар хамгааллын журмыг мөрдөнө.
  - 1.5.6. Өвчтөний нууцлал, бичлэгийн аюулгүй байдлыг хангана.
  - 1.5.7. Цахим аюулгүй байдлыг зэргийн шалгалт өгсөн эмч хариуцна.
  - 1.5.8. Өвчтөнөөс зөвшөөрлийн хуудсыг бичгээр авсан байна.
  - 1.5.9. Өвчтөний зөвшөөрлийн хуудастай хамт гардан үйлдлийн шалгалтаас 7 хоногийн өмнө [mongolia.mfog@gmail](mailto:mongolia.mfog@gmail.com)-рүү google share-ээр илгээсэн байна.
- 1.6. Жирэмсэн, төрөх, төрсний дараах хүндрэл, эмэгтэйчүүдийн өвчин эмгэгээс сэргийлэх, эрт оношлох, эмчлэх мэдлэг, ур чадварыг

эзэмшсэн байна. (Аймаг, дүүргийн амбулатори, клиник, эрүүл мэндийн төв зэрэгт мэргэжлээрээ ажиллаж байгаа эх барих эмэгтэйчүүдийн эмч өөрөө хүсвэл эмнэлзүйн тохиолдолд суурилсан оношилгоо, эмчилгээний асуудлаар шалгалт өгч болно.)

- 1.7. Албан ёсны веб хуудас дээр тавигдсан заавал судлах видео лекцүүдийг үзсэн байна.
- 1.8. Видео лекц үзсэний дараа сорилыг бөглөж, онолын хэсгийн босго 30 оноог авсан байна. (Онолын шалгалт нийт 100 оноо гэж үзэхэд шалгалтад орохдоо 30 онооны болзол хангасан байна.)
- 1.9. Оношилгоо эмчилгээний шинэ техник, аргачлал 2-оос доошгүйг эзэмшсэн байна. (ажлын баталгаажсан тайлан)
- 1.10. Байгууллагынхаа түвшинд оношилгоо, эмчилгээний гарын авлага, зөвлөмж 2-оос доошгүйг боловсруулсан байна. (ажлын баталгаажсан тайлан)
- 1.11. Эзэмшсэн мэргэжлээрээ 1-2 судалгааны ажил хийж, онол практикийн хуралд хэлэлцүүлсэн байна.
- 1.12. Нийтэд болон үйлчлүүлэгч нарт зориулж мэргэжлийн зөвлөгөө, зөвлөмж, санамж 2-оос доошгүйг бичиж сонин, сэтгүүлд хэвлүүлсэн буюу радио, телевизээр нэвтрүүлсэн байна. (сүүлийн 3 жилийн ажлын баталгаажсан тайлан)
- 1.13. Мэргэжлийн холбоо болон салбар зөвлөлийн ажилд идэвх санаачлагатай оролцож холбооны жил тутмын татварыг сүүлийн 3 жил дараалан өгсөн байна. (салбар зөвлөлийн даргын тодорхойлолт)

**Ахлах зэргийн эмч нь ажиллаж байгаа тасаг, сум өрх дүүргийн эрүүл мэндийн төвд зөвлөгөө өгөх чадвар эзэмшсэн байна.**

**2. ТЭРГҮҮЛЭХ** зэрэг горилогч эх барих эмэгтэйчүүдийн эмч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 2.1. Эрүүл мэндийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 2019 оны А/513 дугаар тушаалаар батлагдсан 1 дүгээр хавсралтын 4.2.1-4.2.9 дэх нийтлэг шаардлагыг хангасан байна.
- 2.2. Эх барих эмэгтэйчүүдийн практикт хийгддэг мэс засал, ажилбаруудын техникийг эзэмшсэн байна. Үүнд: умайг дайвартай дайваргүй, умайн хүзүүний дээгүүр болон бүхэлд нь авах мэс засал, өндгөвчийн уйланхай, хавдар (хүндрэлтэй) авах, нөхөн сэргээх мэс засал, эсвэл сорвины жирэмсэн, эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслыг хийдэг байна. (ажлын баталгаажсан тайлан)
- 2.3. Умайг дайвартай дайваргүй, умайн хүзүүний дээгүүр болон бүхэлд нь авах мэс засал, өндгөвчийн уйланхай, хавдар (хүндрэлтэй) авах, нөхөн сэргээх мэс засал, эсвэл сорвины жирэмсэн, эмэгтэйчүүдийн

дурангийн мэс заслуудын аль нэгээр доорх шаардлагыг хангасан видео бичлэг хийсэн байна.

- 2.4. Мэс заслын видео хийх шаарлага ба нууцлал:
  - 2.4.1. 4к бичлэг дэмждэг сүүлийн үеийн гар утас, видео камер ашиглана.
  - 2.4.2. Өндөр нягтралтай (1080p-Full Definition/4k-UHD)
  - 2.4.3. Сүүдэр багатай, тод гэрэлтүүлэгтэй
  - 2.4.4. Гэрэлтүүлгийг зөв байрлалаас тусгана.
  - 2.4.5. Халдвар хамгааллын журмыг мөрдөнө.
  - 2.4.6. Өвчтөнөөс зөвшөөрлийн хуудсыг бичгээр авсан байна.
  - 2.4.7. Өвчтөний нууцлал, бичлэгийн аюулгүй байдлыг хангана.
  - 2.4.8. Өвчтөний зөвшөөрлийн хуудастай хамт гардан үйлдлийн шалгалтаас 7 хоногийн өмнө [mongolia.mfog@gmail](mailto:mongolia.mfog@gmail.com)-рүү google share-ээр илгээсэн байна.
- 2.5. Жирэмсэн, төрөх, төрсний дараах хүндрэл, эмэгтэйчүүдийн өвчин эмгэгээс сэргийлэх, эрт оношлох, эмчлэх, нөхөн сэргээх эмчилгээний ур чадварыг эзэмшсэн байна. (Аймаг, дүүргийн амбулатори, клиник, эрүүл мэндийн төв зэрэгт мэргэжлээрээ ажиллаж байгаа эх барих эмэгтэйчүүдийн эмч өөрөө хүсвэл эмнэлзүйн тохиолдолд суурилсан оношилгоо, эмчилгээний асуудлаар шалгалт өгч болно.)
- 2.6. Албан ёсны веб хуудас дээр тавигдсан заавал судлах видео лекцүүдийг үзсэн байна.
- 2.7. Видео лекц үзсэний дараа сорилыг бөглөж, онолын хэсгийн босго 30 оноог авсан байна. (Онолын шалгалт нийт 100 оноо гэж үзэхэд шалгалтад орохдоо 30 онооны болзол хангасан байна.)
- 2.8. Эмэгтэйчүүдийн үрэвсэлт өвчин, дотоод шүүрлийн, охидын болон цэвэршилтийн хам шинж, эмгэг цус алдалтыг оношлох эмчлэх, нөхөн сэргээх эмчилгээний ур чадварыг эзэмшсэн байна. (ажлын баталгаажсан тайлан)
- 2.9. Аймаг, дүүрэг, байгууллагын түвшинд оношилгоо, эмчилгээ, нөхөн сэргээх чиглэлээр шинэ техник, аргачилал 3-аас доошгүйг эзэмшсэн байна. (ажлын баталгаажсан тайлан)
- 2.10. Аймаг, дүүрэг байгууллагын түвшинд оношилгоо эмчилгээний гарын авлага, зөвлөмж 3-аас доошгүйг боловсруулсан байна. (ажлын баталгаажсан тайлан)
- 2.11. Эзэмшсэн мэргэжлээрээ судалгаа шинжилгээний ажил хийж сүүлийн 5 жилд онол практикийн хуралд 3-аас доошгүй илтгэлийг хэлэлцүүлсэн байна. (илтгэлийн хураангуйн хуулбар)
- 2.12. Шавилан сургалтаар 3-аас доошгүй эмчийг дагалдуулан сургасан байна. (дагалдуулан сургасан эмчийн нэр, сургасан хугацааг тайланд бичнэ)

- 2.13. Мэргэжлийн холбоо болон салбар зөвлөлийн ажилд идэвх санаачлагатай оролцож холбооны жил тутмын татварыг сүүлийн 3 жил дараалан өгсөн байна. (салбар зөвлөлийн даргын тодорхойлолт)

**Тэргүүлэх зэргийн эмч нь аймаг дүүрэг, амаржих газар, ажиллаж буй нэгж байгууллагын эмч нарт зөвлөх чадвартай байна.**

3. **ЗӨВЛӨХ зэрэг горилогч эх барих эмэгтэйчүүдийн эмч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:**
  - 3.1. Эрүүл мэндийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 2019 оны А/513 дугаар тушаалаар батлагдсан 1 дүгээр хавсралтын 4.3.1-4.3.10 дах нийтлэг шаардлагыг хангасан байна.
  - 3.2. Эх барих эмэгтэйчүүдийн практикт хийгддэг бүх төрлийн мэс заслуудын техникийг эзэмшсэн байна. (ажлын баталгаажсан тайлан)
  - 3.3. Жирэмсэн, төрөх, төрсний дараах хүндрэл, эмэгтэйчүүдийн өвчин эмгэгээс сэргийлэх, эрт оношлох, эмчлэх, нөхөн сэргээх эмчилгээний мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байна. (ажлын баталгаажсан тайлан)
  - 3.4. Албан ёсны веб хуудас дээр тавигдсан заавал судлах видео лекцүүдийг үзсэн байна.
  - 3.5. Байгууллага, тасаг нэгжийн эрхлэгч эсвэл зөвлөхөөр ажиллаж байгаа болон ажиллаж байсан.
  - 3.6. Үндэсний болон аймаг, дүүрэг, амаржих газарт мөрдөх оношилгоо, эмчилгээний удирдамж, зөвлөмж, ном, гарын авлага 3-аас доошгүйг боловсруулсан байна. (ажлын баталгаажсан тайлан)
  - 3.7. Үндэсний болон аймаг, дүүрэг, амаржих газрын түвшинд хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр, стратеги, төсөл, төлөвлөгөө, заавар, журам 3-аас доошгүйг санаачилсан, хамтран боловсруулсан байна. (ажлын баталгаажсан тайлан)
  - 3.8. Эзэмшсэн мэргэжлээрээ 4-өөс доошгүй судалгааны ажил хийж онол практикийн хуралд илтгэл тавьж хэлэлцүүлсэн байна.(илтгэлийн хураангуйн хуулбар)
  - 3.9. Тухайн мэргэжлээрээ сургалт семинар, онол практикийн хурал, зөвлөгөөнийг удирдан зохион байгуулсан байна. (сүүлийн 5 жилийн ажлын баталгаажсан тайлан)
  - 3.10. Өөрийн мэргэжлийн чиглэлээр эмчилгээ оношилгооны шинэ технологи 4-өөс доошгүйг эзэмшсэн байна.
  - 3.11. Шавилан сургалтаар 5 ба түүнээс дээш тооны мэргэжлийн эмчийг дагалдуулан сургаж үр дүнд хүргэсэн байна. (ажлын баталгаажсан тайлан)

- 3.12. Мэргэжлийн холбоо болон салбар зөвлөлийн ажилд идэвх санаачлагатай оролцож холбооны жил тутмын татварыг сүүлийн 5 жил дараалан өгсөн байна. (салбар зөвлөлийн даргын тодорхойлолт)

**Зөвлөх зэргийн эмч үндэсний болон аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв, амаржих газар, тасаг болон бусад эмнэлгийн эмч мэргэжилтэнд зөвлөх чадвартай байна.**